

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ АРВАНХОЁРДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2017 оны тавдугаар сарын 10 -ны 14 цаг 07 минутад эхэлж, 15 цаг 04 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, 57 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Б.Болдбаатарыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, иргэн Б.Болдбаатарын хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн: Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар 2012 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс 2016 оны 07 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд томилогдон ажиллаж байсан Бямбадоржийн Болдбаатарыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Баянхонгор аймгийн Засаг даргаар ажиллаж байсан Д.Амарсанааг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, иргэн Б.Болдбаатарын хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн: Баянхонгор аймгийн Засаг даргаар 2008 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 2012 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд томилогдон ажиллаж байсан Дагвадоогийн Амарсанааг

		<p>төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>"Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.8, 35 дугаар зүйлийн 35 дугаар зүйлийн 35.1.9, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 4.5-д заасныг баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам"-д дараах нэмэлт, өөрчлөлт оруулах</p> <p>1.1. Журмын 9.2 дахь хэсгийн "...дэргэдэх Төрийн албаны институтын..." гэснийг "...Ажлын албаны..." гэж, 9.4 дахь хэсгийн "...дэргэдэх Төрийн албаны институт..." гэснийг "...Ажлын алба..." гэж, 9.5 дахь хэсгийн "...институт..." гэснийг "...Ажлын алба..." гэж тус тус өөрчлөх.</p> <p>1.2. Журмын 4.2 дахь хэсгийг "Төв комиссын дарга нь Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн, нарийн бичгийн дарга нь Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны тухайн асуудлыг хариуцсан ажилтан байна. Төв комиссын бүрэлдэхүүнд Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга, Ажлын албаны салбар зөвлөл хариуцсан ажилтан, Нийслэл дэх Салбар зөвлөлийн орон тооны нарийн бичгийн даргаас гадна Улсын Их Хурлын Тамгын газар,</p>

		<p>Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны төлөөлөл орно.” гэж, 4.3 дахь хэсгийг “Төрийн албаны зөвлөл Төв комиссыг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна” гэж тус тус өөрчлөн найруулах.</p> <p>2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг мэргэшлийн шалгалтын Төв комисст үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Мэргэшлийн Төв комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 4.1, 4.2-т дахь хэсгийг баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны мэргэшлийн шалгалтын Төв комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар батлах</p> <p>2. “Мэргэшлийн шалгалтын төв комиссын бүрэлдэхүүнийг батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 45 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
5	<p>Баянхонгор аймаг болон Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо нөхөх мэргэшлийн шалгалтын дүн</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйл, Баянхонгор аймаг дахь Салбар зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 04 дүгээр хуралдааны шийдвэр, төрийн албаны мэргэшлийн шалгалтад</p>

		<p>тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 91 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 14 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэгд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс гуравдугаар хавсралтад дурдсан хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 10 иргэн, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс дөрөвдүгээр хавсралтад дурдсан хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 9 иргэн, нийт 19 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх</p> <p>3. Тогтоолын хоёрт дурдсан нэр бүхий 19 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн</p>
--	--	---

	<p>Баянхонгор аймаг дахь Салбар зөвлөл /Ц.Дашцэрэн/-д үүрэг болгох</p> <p>4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамбад даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйл, Нийслэл дэх Салбар зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 04-гы өдрийн 27 дугаар тогтоол, төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 439 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 141 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэгд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс гуравдугаар хавсралтад дурдсан хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 47 иргэн, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох</p>
--	---

		<p>иргэний нөөц"-д бүртгэгдсэн иргэдээс дөрөвдүгээр хавсралтад дурдсан хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 2 иргэн, нийт 49 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх</p> <p>3. Тогтоолын хоёрт дурдсан нэр бүхий 49 иргэнийг "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх Салбар зөвлөл /М.Отгонбаяр/-д үүрэг болгох</p> <p>4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамбад даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
6	Төрийн албаны зөвлөлийн Сүхбаатар аймаг дахь Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	Төрийн албаны зөвлөлийн Сүхбаатар аймаг дахь Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай асуудлыг хэлэлцээд, Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд багтах аймгийн Засаг даргын Тамгын газрын нэгжийн бүтцийн удирдлагад багтан ажиллаж байгаа зарим хүмүүс хууль бус томилгоотой үндэслэлээр шүүхэд маргаан үүсгэн хандсан байгаа тул энэхүү асуудлыг шийдвэрлэтэл Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах асуудлыг түр хойшлуулахаар шийдвэрлэв.

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
АЖЛЫН АЛБА**